

**МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ**

**БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛТНЫГ ДАВТАН СУРГАХ,
МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ,
СУНГАХ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, СУРГАЛТ ЭРХЛЭХ
ЧИГ ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭХ ТӨРИЙН БУС, МЭРГЭЖЛИЙН
БАЙГУУЛЛАГЫН ТҮНШЛЭЛИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ**

2023 он

ГАРЧИГ

1. Танилцуулга
 - 1.1. Уралдаант шалгаруулалтын баримт бичгийн зорилго
 - 1.2. Нэр томъёоны тайлбар
2. Уралдаант шалгаруулалтын мэдээлэл
 - 2.1. Уралдаанд шалгаруулалтыг зохион байгуулах үндэслэл
 - 2.2. Уралдаан шалгаруулалтад шалгарсан оролцогчийн хийж гүйцэтгэх ажлын цар хүрээ
3. Оролцогчдод өгөх зааварчилгаа
 - 3.1. Танилцуулга
 - 3.2. Уралдаан шалгаруулалтын хуваарь
 - 3.3. Албан ёсны хэл
 - 3.4. Оролцогч тодруулга хүсэх
 - 3.5. Үнэлгээний өмнөх уулзалт
 - 3.6. Ерөнхий шаардлагын мэдээлэл
 - 3.7. Хүний нөөцийн чадавхын санал
 - 3.8. Материаллаг бааз, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн санал
 - 3.9. Түншлэл
4. Уралдаант шалгаруулалтын материалын иж бүрдэл, битүүмжлэл, санал хүчинтэй байх хугацаа
 - 4.1. Уралдаант шалгаруулалтын саналын иж бүрдэл
 - 4.2. Уралдаант шалгаруулалтын саналын битүүмжлэл
 - 4.3. Уралдаант шалгаруулалтад ирүүлсэн санал хүчинтэй байх хугацаа
5. Уралдаант шалгаруулалтын журам
 - 5.1. Уралдаант шалгаруулалт зарлах
 - 5.2. Оролцогчдын саналыг хүлээн авах
 - 5.3. Оролцогчийн ирүүлсэн санал болон холбогдох материалыг нээх, үнэлэх, оролцогчийг сонгон шалгаруулах
 - 5.4. Шалгуур үзүүлэлт
6. Хавсралтууд:
 - 6.1. Маягт 1. Уралдаант шалгаруулалтын саналын мэдүүлэг;
 - 6.2. Маягт 2. Уралдаант шалгаруулалтад санал болгож байгаа хүний нөөцийн мэдээлэл;

6.3.Маягт 3.Үйл ажиллагаа эрхэлдэг ажлын байрны болон сургалтын байрны талаар мэдээлэл

6.4.Маягт 4.Барилгын салбарын норм, нормативын баримт бичиг жагсаалт:

6.5.Маягт 5.Сургалтад ашиглаж буй барилгын салбарын шинжлэх ухаан, техник, технологийн талаарх гарын авлага, ном товхимлын жагсаалт

6.6.Маягт 6. Уралдаант шалгаруулалтад санал болгож байгаа тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл;

7. Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх гэрээ

8. Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгэх төрийн бус, мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтын ажлын даалгавар

Нэг. Танилцуулга

1.1. Энэхүү уралдаант шалгаруулалтын баримт бичиг /Цаашид “Баримт бичиг” гэх/ нь барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, сургалт зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгэх төрийн бус, мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалт /Цаашид “Уралдаант шалгаруулалт” гэх/-д оролцогчид өгөх зааварчилгаа, санал ирүүлэх маягтуудыг багтаасан болно. Ажлын хэсэг уралдаант шалгаруулалтад оролцогчийн энэ баримт бичигт заасан маягтын дагуу ирүүлсэн саналыг энэ баримт бичигт заасан үнэлгээгээр үнэлж, хамгийн өндөр оноо авсан оролцогчийг шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгох үйл ажиллагаанд энэхүү баримт бичгийг ашиглана.

1.2. Уралдаант шалгаруулалтын баримт бичгийн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1. “Оролцогч” гэж уралдаант шалгаруулалтад оролцох санал ирүүлсэн этгээдийг;

1.2.2. “Уралдаант шалгаруулалтын санал” гэж оролцогчдоос энэ баримт бичгийн хавсралтад тусгасан маягтыг бүрэн бөглөж ирүүлсэн санал, түүнийг нотлох баримтуудыг;

1.2.3. “Түншлэл” гэж уралдаант шалгаруулалтад Иргэний хуулийн 476 дугаар зүйлд заасан Хамтран ажиллах гэрээ байгуулан оролцож байгаа төрийн бус байгууллагуудын нэгдлийг;

1.2.4. “Уралдаант шалгаруулалтын баримт бичиг” гэж оролцогчдод олгох шалгуур үзүүлэлтүүд, шаардлагатай бусад мэдээллийг тусгасан баримт бичгийг;

1.2.5. “Ажлын хэсэг” гэж Уралдаант шалгаруулалтыг зохион байгуулж буй комиссыг.

Хоёр. Уралдаант шалгаруулалтын мэдээлэл

2.1. Уралдаант шалгаруулалт зохион байгуулах үндэслэл

Барилгын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 44 дүгээр зүйлийн 44.7, Иргэний хуулийн 421.1, “Жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2010 оны 325 дугаар тогтоол, “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 340 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэжлийн зэрэг олгох дүрэм”-ийн 3.3, “Төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 250 дугаар тушаалыг тус тус үндэслэсэн.

2.2. Уралдаант шалгаруулалтад шалгарсан оролцогчийн хийж гүйцэтгэх ажлын цар хүрээ

Уралдаант шалгаруулалтад шалгарсан оролцогч нь Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэжлийн зэрэг олгох дүрэм” /Цаашид “Дүрэм” гэх/-ийн 3.5.6, 3.5.7, 3.5.10, 3.5.11, 3.5.13-т заасан чиг үүрэг болон

дүрмийн 1 дүгээр хавсралтын үйл ажиллагааны хүрээ 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.23-т зааснаас бусад барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, сургалт зохион байгуулах, эрхлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.

Гурав. Оролцогчдод өгөх зааварчилгаа

3.1.Ажлын хэсэг уралдаант шалгаруулалтыг энэ зүйл болон энэ баримт бичгийн 5 дугаар зүйлд заасан журмын дагуу зохион байгуулах бөгөөд оролцогч нь энэ баримт бичгийн хавсралтад заасан маягтыг бүрэн бөглөж саналаа ирүүлнэ.Энэ шаардлагыг хангаагүй материалыг Ажлын хэсэг иж бүрдэл дутуу гэж үзэн үнэлэхээс татгалзана.

3.2.Уралдаант шалгаруулалтыг дараах хуваарийн дагуу явуулна:

Агуулга	Огноо:
Уралдаант шалгаруулалтын баримт бичиг олгож эхлэх	2023-12-04
Уралдаант шалгаруулалтын баримт бичигтэй холбоотой тодруулга авах хүсэлт ирүүлэх эцсийн хугацаа	2023-12-12-ны 17 цаг 30 минутаас өмнө
Уралдаант шалгаруулалтын санал хүлээн авах эцсийн хугацаа	2023-12-19-ний 17 цаг 30 минутаас өмнө

3.3. Албан ёсны хэл

Уралдаант шалгаруулалттай холбоотой аливаа харилцааг монгол хэлээр явуулна.

3.4. Оролцогч тодруулга хүсэх

3.4.1.оролцогч уралдаант шалгаруулалттай холбоотой аливаа тодруулга авах хүсэлтийг доорх хаягийн дагуу албан бичгээр гаргаж болно.

Байгууллагын нэр: Барилга, хот байгуулалтын яам

Хаяг: Улаанбаатар 15170, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Барилгачдын талбай 3, Засгийн газрын 12 дугаар байр

Хариуцсан албан тушаалтан: Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Г.Гантөр

3.4.2.Уралдаант шалгаруулалтыг ажлын хэсэг /Цаашид “Ажлын хэсэг” гэх/-ийн нарийн бичгийн дарга тодруулга хүссэн албан бичгийг Барилга, хот байгуулалтын яамны бичиг хэргээр дамжуулан хүлээн авах бөгөөд Ажлын хэсгийн даргад танилцуулна.

3.4.3.Ажлын хэсгийн дарга тодруулга өгөх ажлыг зохион байгуулж хүсэлт гаргасан этгээдийг дурдалгүйгээр хариуг бүх оролцогчид зэрэг бичгээр, эсхүл энэ баримт бичгийн 3.5-д заасан үнэлгээний өмнөх уулзалтаар өгнө. Тодруулга авах хүсэлтийг 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 17 цаг 30 минутаас өмнө ирүүлэх бөгөөд хоцорч ирсэн хүсэлтэд хариу өгөхгүй.

3.5. Үнэлгээний өмнөх уулзалт

3.5.1.ажлын хэсэг нь үнэлгээний өмнөх уулзалтыг уралдаант шалгаруулалтын хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө Улаанбаатар 15170, Чингэлтэй дүүргийн 4-р хороо, Барилгачдын талбай гудамж, Засгийн газрын 12 дугаар байранд байрлах Барилга, хот байгуулалтын яамны хурлын танхимд 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 15:00 цагт зохион байгуулна.

3.5.2.оролцогч нь уулзалтад оролцох хүний нэрийг уулзалт болохоос 3 хоногийн өмнө Ажлын хэсэгт gantur@mcud.gov.mn хаягаар мэдэгдэнэ.

3.5.3.үнэлгээний өмнөх уулзалтын зорилго нь уралдаант шалгаруулалтын баримт бичигтэй холбоотой аливаа асуултад хариулт өгөх, тодруулга хийхэд оршино. Уулзалтын үеэр өгсөн хариулт, энэхүү баримт бичгийн 3.4.3-ын дагуу өгсөн хариулт хоорондоо зөрсөн тохиолдолд албан бичгээр өгсөн хариултыг хүчинтэйд тооцно.

3.5.4.үнэлгээний өмнөх уулзалтын үеэр тавигдсан асуултауд тэдгээрийн хариултуудыг багтаасан уулзалтын тэмдэглэлийг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хөтөлж, Ажлын хэсгийг дарга хянаж албажуулна.

3.5.5.уулзалтад оролцоогүй, уулзалтын үеэр аливаа тодруулга хүсээгүй нь оролцогчийг шаардлага хангаагүйд тооцох үндэслэл болохгүй.

3.6.Ерөнхий шаардлагын мэдээлэл:

3.6.1.оролцогч нь энэ баримт бичгийн 5.3.3.а-д заасан материалыг бүрдүүлж ирүүлнэ.

3.7.Хүний нөөцийн чадавхын санал:

3.7.1.оролцогчоос ирүүлэх хүний нөөцийн чадавхын саналд барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах боловсон хүчний боловсрол, мэргэшсэн байдал, туршлагын талаарх мэдээллийг энэ баримт бичгийн Маягт 2-д тусган, холбогдох нотлох баримтыг хавсарган ирүүлнэ.

3.8.Материаллаг бааз, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн санал:

3.8.1.оролцогчоос ирүүлэх материаллаг бааз, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн саналд барилгын салбарын сургалт зохион байгуулах, сургалтын үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай ажлын болон сургалтын байр, түншлэлийн гишүүн нь барилгын салбарын шинжлэх ухаан, техник, технологийн болон салбарын мэргэжлийн сургалтын гарын авлага, ном товхимол, норм нормативын баримт бичгийн жагсаалт, техник хэрэгслийн зориулалт, хүчин чадал, тоо ширхгийн талаарх мэдээллийг Маягт 3, 4, 5, 6-д тусган ирүүлнэ.

3.9. Түншлэл

3.9.1.Барилгын салбарын сургалт эрхлэгч төрийн бус, мэргэжлийн байгууллагууд нь Иргэний хуулийн 476 дугаар зүйлийн 476.3-т заасан шаардлагыг хангасан хамтран ажиллах гэрээ байгуулан түншлэлээр оролцох бөгөөд холбогдох хүний нөөцийн мэдээллээ Маягт 2-д тусган, холбогдох нотлох баримтын хамтаар ирүүлнэ.

3.9.2.Түншлэлийн гишүүд уг уралдаант шалгаруулалтад өөр байгууллагатай түншлэн оролцохыг хориглоно.

Дөрөв.Уралдаант шалгаруулалтын баримт бичгийн иж бүрдэл, саналын битүүмжлэл

4.1.Уралдаант шалгаруулалтын баримт бичиг нь энэ баримт бичгийн хавсралтад заасан маягтын дагуу ирүүлсэн санал, түүнийг нотолсон баримтаас бүрдэнэ.

4.2.Энэ зүйлийн 4.1-д заасан саналын цаасан болон цахим хувийг битүүмжлэн, дугтуйд доорх тэмдэглэгээг хийж ирүүлнэ.

УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР.....

ОРОЛЦОГЧ

ХАЯГ

4.3. Уралдаант шалгаруулалтын саналын цахим хувиудыг Microsoft Excel, Adobe PDF хэлбэрүүдээр бэлтгэн CD-нд буулгасан байна.

4.4. Уралдаант шалгаруулалтын санал нь энэ баримт бичгийн 3.2-т заасан санал хүлээн авах эцсийн хугацаа дууссанаас хойш хуанлийн 45 хоног хүчинтэй байна.

Тав.Уралдаант шалгаруулалтын журам

5.1. Уралдаант шалгаруулалт зарлах:

5.1.1.Уралдаант шалгаруулалтын зарыг Барилга, хот байгуулалтын яам болон “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын цахим хаягаар дамжуулан нийтэд мэдээлнэ;

5.1.2.Уралдаант шалгаруулалтад нээлттэй өрсөлдөөн өрнүүлэх зорилгоор барилгын салбарын төрийн бус, мэргэжлийн байгууллагуудыг уулзалтад урьж болно;

5.2.Оролцогчийн саналыг хүлээн авах:

5.2.1.Ажлын хэсэг нь уралдаант шалгаруулалтын зар мэдээг нийтэд мэдээлснээс хойш, оролцогчийн саналыг хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө оролцогчдын санал, холбогдох материалыг хүлээн авна;

5.2.2.Оролцогч нь уралдаант шалгаруулалтад оролцох санал болон холбогдох материалаа энэ баримт бичгийн 4 дүгээр зүйлд заасны дагуу битүүмжлэн ирүүлнэ;

5.2.3. Ажлын хэсэг хугацаа хоцорсон, эсхүл битүүмжлэлгүйгээр ирүүлсэн уралдаант шалгаруулалтын санал болон холбогдох материалыг хүлээж авахгүй;

5.2.5.Оролцогчийн ирүүлсэн санал болон холбогдох материалыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга бүртгэн хүлээж авна.

5.3. Оролцогчийн ирүүлсэн санал болон холбогдох материалыг нээх, үнэлэх, оролцогчийг сонгон шалгаруулах:

5.3.1.Ажлын хэсэг оролцогчдын ирүүлсэн санал болон холбогдох материалын бүрдлийг шалгана.

5.3.2.Оролцогч нь уралдаант шалгаруулалтын хавсралтад заасан Маягтыг дутуу бөглөж ирүүлсэн бол ажлын хэсэг тухайн материалыг судлан үзэж, үнэлгээ хийхээс татгалзаж, тэнцээгүйд тооцно.

5.3.3.Ажлын хэсэг уралдаант шалгаруулалтад энэ баримт бичгийн хавсралтад заасан маягтын дагуу оролцогчийн ирүүлсэн санал, түүнийг нотолсон баримтыг үндэслэн дараах шалгуур үзүүлэлтийг харгалзан үнэлнэ:

А.Ерөнхий шаардлагын үзүүлэлт:

Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн авбал зохих оноо
Тухайн байгууллагын дэлгэрэнгүй танилцуулга	0-1
Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	0-1
Дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	0-1
Сүүлийн 2 жилийн үйл ажиллагааны тайлангийн хуулбар	0-1
Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлангийн хуулбар.	0-1
Нийт оноо	5

Б.Материаллаг бааз, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн санал:

Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн оноо	Нийт оноо
Үйл ажиллагаа эрхэлдэг ажлын байр болон сургалтын байрны талбайн хэмжээг харгалзан	- 15-аас дээш хүний суудалтай анги танхимтай, 5 ба түүнээс дээш тасалгаатай бол	10
	- 15-аас дээш хүний суудалтай анги танхимтай, 3-5 өрөө тасалгаатай бол	8
	- 15 хүртэлх хүний суудалтай анги танхимтай бол 2 хүртэл өрөө тасалгаатай бол	0-5
Сургалт эрхлэгч нь барилгын салбарын шинжлэх ухаан, техник, технологийн болон салбарын мэргэжлийн ном товхимол болон сургалтын гарын авлага, бүтээл, норм, нормативын баримт бичгийн жагсаалт	0-2	2
Сургалтад ашиглах тоног төхөөрөмж, техник хэрэгслийн жагсаалт, түүний тоо, хүчин чадлын үзүүлэлтийг харгалзан	0-2	30
Үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөтэй байх	0-3	3
Нийт оноо		45

В. Хүний нөөцийн чадавхын санал:

Сургалтын албаны хүний нөөцийн саналын шалгуур үзүүлэлт :

Шалгуур үзүүлэлт			
Боловсрол зэрэг	Мэргэшлийн зэрэг	Оноо	Нийт оноо
Барилгын салбарын доктортой	- Зөвлөх зэрэгтэй архитектор -Зөвлөх зэрэгтэй инженер -Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин	16-20	20
Барилгын салбарын доктортой	-мэргэшсэн зэрэгтэй бол		
Барилгын салбарын магистр	- Зөвлөх зэрэгтэй архитектор -Зөвлөх зэрэгтэй инженер -Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин		
Барилгын салбарын магистр-2 ба түүнээс дээш	-Мэргэшсэн зэрэгтэй бол		
Барилгын салбарын доктортой	-мэргэшсэн зэрэгтэй бол	11-15	
Барилгын салбарын магистр	- Зөвлөх зэрэгтэй архитектор -Зөвлөх зэрэгтэй инженер -Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин		
Барилгын салбарын магистр-2 ба түүнээс дээш	-Мэргэшсэн зэрэгтэй бол		
Барилгын салбарын магистр	- Зөвлөх зэрэгтэй архитектор -Зөвлөх зэрэгтэй инженер -Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин	6-10	
Барилгын салбарын магистр-2 ба түүнээс дээш	-Мэргэшсэн зэрэгтэй бол		
Барилгын салбарын магистр ба түүнээс дээш	-Мэргэшсэн зэрэгтэй бол	0-5	

Сургалт зохион байгуулагч, эрхлэгчийн хүний нөөцийн саналын шалгуур үзүүлэлт:

Шалгуур үзүүлэлт			
Боловсрол зэрэг	Мэргэжлийн зэрэг	Оноо	Нийт оноо
Доктор-6 ба түүнээс дээш	- Зөвлөх зэрэгтэй архитектор -Зөвлөх зэрэгтэй инженер -Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин	15	15
Доктор-6 ба түүнээс дээш	- Зөвлөх зэрэгтэй архитектор - Зөвлөх зэрэгтэй инженер - Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин - Мэргэшсэн зэрэгтэй архитектор, инженер, төсөвчин	10	
Доктор-5 хүртэл	- Зөвлөх зэрэгтэй архитектор	0-5	

	- Зөвлөх зэрэгтэй инженер - Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин - Мэргэшсэн зэрэгтэй архитектор, инженер, төсөвчин		
Тайлбар: Доктор нь барилгын салбарын мэргэжлийн үйл ажиллагааны хүрээ тус бүрээс 1 хүн байна. Хэвээр нэг хүрээнээс 2 ба түүнээс дээш докторын материалыг санал болгосон бол нэг хүний материалаар тооцно.			
Магистр-15 ба түүнээс дээш	-Зөвлөх зэрэгтэй архитектор -Зөвлөх зэрэгтэй инженер -Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин	15	15
Магистр-15 ба түүнээс дээш	-Зөвлөх зэрэгтэй архитектор - Зөвлөх зэрэгтэй инженер - Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин - Мэргэшсэн зэрэгтэй архитектор, инженер, төсөвчин	10	
Магистр-15 хүртэл	- Зөвлөх зэрэгтэй архитектор - Зөвлөх зэрэгтэй инженер - Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин - Мэргэшсэн зэрэгтэй архитектор, инженер, төсөвчин	0-5	
Хүний нөөцийн чадавхын саналын нийт үнэлгээ		50 оноо	

6. Хавсралтууд:

6.1.Маягт 1. Уралдаант шалгаруулалтын саналын мэдүүлэг;

6.2.Маягт 2. Сонгон шалгаруулалтад санал болгож байгаа хүний нөөцийн мэдээлэл;

6.3.Маягт 3. Үйл ажиллагаа эрхэлдэг ажлын байрны болон сургалтын байрны талаар мэдээлэл;

6.4. Маягт 4. Сургалтыг үйл ажиллагаанд ашиглаж буй норм нормативын баримт бичгийн жагсаалт;

6.5.Маягт 5.

6.6.Маягт 6.Уралдаант шалгаруулалтад санал болгож байгаа үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл;

Маягт 1. УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТЫН САНАЛЫН МЭДҮҮЛЭГ

Огноо:

Хэнд: [Эрх бүхий этгээдийн нэр]

[Уралдаант шалгаруулалтын нэр]

Уралдаант шалгаруулалтын саналын мэдүүлэг

Бид уралдаант шалгаруулалтын баримт бичиг, түүний бүх хавсралт, тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүрэн хүлээн авсан бөгөөд эдгээртэй сайтар танилцаж, бүрэн ойлгосон гэдгээ үүгээр нотолж байна.

Бид уралдаант шалгаруулалтын баримт бичигт тусгасан шаардлагуудад нийцүүлэн, оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу, төслийн саналаа үнэн зөв, бүрэн гүйцэд бэлтгэсэн бөгөөд, төслийн санал нь төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [уралдаант шалгаруулалтын санал хүчинтэй байх хугацааг бичих] хоног хүртэл хүчинтэй, үл буцаах гэдгийг баталж, үүгээр хүргүүлж байна.

Уралдаант шалгаруулалтыг дуусах хүртэл бидэнтэй харилцах хаяг:

[Оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, холбоо барих хаяг]

Хүндэтгэсэн,

[Оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, албан тушаал, гарын үсэг]

--o0o--

Маягт 2. УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТАД САНАЛ БОЛГОЖ БАЙГАА ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭДЭЭЛЭЛ

Маягт 2.1.Сургалт зохион байгуулагчийн сургалтын албаны хүний нөөцийн мэдээлэл

Тухайн байгууллагад эрхэлж буй албан тушаал	Ажилтны эцэг/эх, өөрийн нэр	Мэргэжил, Боловсролын зэрэг	Мэргэшлийн зэрэг	Ажилласан жил
Сургалтын менежер				
..... хариуцсан ажилтан.....				
.....хариуцсан ажилтан.....				
<p>Дээр мэдээллийг дараах баримт бичгээр нотолсон байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Ажилд томилсон тушаалын хуулбар; • Хөдөлмөрийн гэрээ болон түүнтэй адилтгах бусад гэрээний хуулбар; • Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, лавлагаа; • Боловсролыг гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар; • Мэргэжлийн зэргийн гэрчилгээний хуулбар зэргээр нотолсон байна. 				

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, ур чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байгаа бөгөөд үүнийг нотлох холбогдох бүхий л баримт материалаа хавсаргаж ирүүлсэн болно.

МЭДЭЭЛЭЛ ГАРГАСАН:

..... /Албан тушаал/ /Овог, нэр/ /Гарын үсэг/

МЭДЭЭЛЛИЙГ БАТАЛСАН ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД:

..... /Албан тушаал/ /Овог, нэр/ /Гарын үсэг/

---o0o---

Маягт 2.2. Түншлэлийн гишүүдийн сургагч багш нарын мэдээлэл:

Д/д	Асуулт	Хариулт					
Ерөнхий мэдээлэл:							
1.	Байгууллагын нэр:						
2.	Овог, нэр :						
3.	Мэргэжил:						
4.	Төрсөн он сар өдөр:						
5.	Регистрийн дугаар:						
5.	Мэргэжлийн холбооны гишүүнчлэл:						
6.	Хариуцсан ажил:						
Боловсрол, мэргэшсэн байдлын талаарх мэдээлэл:							
Д/д	Сургуулийн нэр	Эзэмшсэн мэргэжил	Боловсролын зэрэг	Дипломын дугаар	Мэргэшлийн зэрэг	Элсэн орсон он	Төгсөн он
1.							
2.							
Д/д	Ажилласан байгууллага	Албан тушаал	Орсон он, сар, өдөр		Гарсан он, сар, өдөр		
1.							
2.							
<p>Дээрх мэдээллийг дараах баримт бичгээр нотолсон байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Тушаалын хуулбар • Ажиллаж байсан болохыг нотолсон баримт /Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар эсхүл Нийгмийн даатгалын лавлагаа, эсхүл ХХОАТ төлсөн баримт/; • Боловсролыг гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар; • Мэргэжлийн зэргийн гэрчилгээний хуулбар зэргээр нотолсон байна. <p>Тайлбар: “Түншлэлийн гишүүд” гэдэгт сургалт зохион байгуулагч болон сургалт эрхлэгч төрийн бус, мэргэжлийн байгууллагууд бүгд хамаарна. Мөн сургалт эрхлэгчийн сургалтын албаны мэргэжилтэн нь сургагч багш бол холбогдох мэдээллийг энэ маягтад тусган, холбогдох материалыг хуулбарлан ирүүлнэ.</p>							

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, ур чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

МЭДЭЭЛЭЛ ГАРГАСАН:

.....

/Албан тушаал/

/Овог, нэр/

/Гарын үсэг/

МЭДЭЭЛЛИЙГ БАТАЛСАН ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД:

.....

/Албан тушаал/

.....

/Овог, нэр/

.....

/Гарын үсэг/

---o0o---

Маягт 3. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛДЭГ АЖЛЫН БАЙРНЫ БОЛОН СУРГАЛТЫН БАЙРНЫ ТАЛААР МЭДЭЭЛЭЛ

3.1. Ажлын байр /оффис/-ны талаарх мэдээлэл

Хаяг/байршил	Эзэмшиж эсхүл ашиглаж байгаа талбайн хэмжээ	["Өөрийн эзэмшил" эсхүл "түрээс" аль нь болохыг бичих]

3.2. Сургалтын анги/танхимын талаарх мэдээлэл

Хаяг/байршил	талбайн хэмжээ	Суудлын тоо, өрөөний тоо	["Өөрийн эзэмшил" эсхүл "түрээс" аль нь болохыг бичих]

Маягт 3.1, 3.2-д заасан мэдээллийг нотолсон ажлын болон сургалтын байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл үл хөдлөх эд хөрөнгө хөлслөх /түрээслэх/ гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.

--- ооо ---

Маягт 4

БАРИЛГЫН САЛБАРЫН НОРМ, НОРМАТИВЫН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ:

Хууль тогтоомжийн жагсаалт:		
д/д	Нэр	Батлагдсан огноо
1.	
Дүрэм, журын жагсаалт:		
д/д	Нэр	Батлагдсан огноо
1.	
Барилга байгууламжийн норм, дүрэм, техникийн дүрэм, заавар, цомог, аргачлал, стандартын жагсаалт:		
д/д	Нэр	Батлагдсан огноо
1.	

Маягт 5. СУРГАЛТАД АШИГЛАЖ БУЙ БАРИЛГЫН САЛБАРЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ТАЛААРХ ГАРЫН АВЛАГА, НОМ ТОВХИМЛЫН ЖАГСААЛТ:

Шинжлэх ухаан, техник, технологийн талаарх ном, товхимлын жагсаалт			
д/д	Зохиогчийн нэр	Бүтээлийн нэр	Хэвлэгдсэн он
1.		

--o0o--

Маягт 6. УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТАД САНАЛ БОЛГОЖ БАЙГАА ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Маягт 6.1. Үйл ажиллагаанд ашиглаж буй тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Үйл ажиллагаанд ашиглаж буй тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	<i>["Өөрийн эзэмшил" эсхүл "түрээс" аль нэгийг бичих]</i>

Маягт 6.2. Сургалтад ашиглаж буй тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Сургалтад ашиглаж буй тоног төхөөрөмж, программ хангамжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	<i>["Өөрийн эзэмшил" эсхүл "түрээс" аль нэгийг бичих]</i>

--o0o--

**БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛТНЫГ ДАВТАН СУРГАХ, МЭРГЭЖИЛ
ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ АЖЛЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЧИГ ҮҮРГИЙГ
ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ**

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар:

Улаанбаатар
хот

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.“Барилгын тухай” хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1, 34 дүгээр зүйлийн 34.1.3, 34.2, 36 дугаар зүйлийн 36.1, 44 дүгээр зүйлийн 44.7, “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоол, “Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай” Барилга хот байгуулалтын сайдын оныдугаар сарын-ны өдрийндүгээр тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор нэг талаас Барилга, хот байгуулалтын яам /цаашид “яам” гэх/, нөгөө талаас түншлэгч төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагыг төлөөлж “.....” төрийн бус байгууллага /цаашид “.....” гэх/ нар харилцан тохиролцож “Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах” чиг үүргийг үргэлжлүүлэн гүйцэтгүүлэхээр энэхүү гэрээг 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр байгуулав.

1.2.Гэрээний хугацаа 1 /нэг/ жил байна.

1.3.Талууд Барилгын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм батлах тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалаар баталсан “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм”, Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 155 дугаар тушаалаар баталсан “Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл”-ийн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

**Хоёр. Барилга, хот байгуулалтын яамны
хүлээх эрх, үүрэг**

2.1.Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах,сургалт эрхлэхтэй холбоотой хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөр боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэхэд зохион байгуулагчын оролцоог хангаж, хамтран ажиллана.

2.2. Хууль тогтоомж, тушаал, шийдвэрийн хэрэгжилт болон гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр дүгнэж, хяналт тавьж ажиллана.

2.3.Энэ гэрээний 2.2-д заасан ажлын санал, дүгнэлтийг Барилга, хот байгуулалтын сайдад танилцуулж, сунгах эсэх асуудлыг шийдвэрлүүлнэ.

2.4.Энэ гэрээний 4.2-т заасны дагуу гэрээг цуцлах асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

Гурав.ын эрх, үүрэг

3.1. Энэхүү гэрээнд заасан Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах зэрэг ажлыг зохион байгуулах чиг үүргээ гүйцэтгэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмыг удирдлага болгоно.

3.2. Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, сургалтын чанар, ажилтнуудын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг боловсронгуй болгох, оновчтой зохион байгуулах санал, санаачилга гаргаж, эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлэх, бусад шаардлагатай асуудлаар яаманд санал тавьж шийдвэрлүүлнэ.

3.3. Сургалт зохион байгуулах зардал буюу мэргэжил дээшлүүлэх сургалтын төлбөрийн жишиг хэмжээг “Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл” /цаашид “Зөвлөл” гэх/-өөр батлуулна. Сургалтын төлбөрт элсэгчийг бүртгэх, сургалтыг зохион байгуулах /мэргэшлийн зэрэг олгох мөн адил хамаарна/ -тай холбоотой зардал багтана.

3.4. Сургалт зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэхдээ сургалт эрхлэх чиг үүрэг хүлээсэн түншлэгч байгууллагуудын мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг нэгтгэн төлөвлөж, зохион байгуулах ажлыг нь мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж зохион байгуулна.

3.5. Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм”-ийн 3.5.6, 3.5.7, 3.5.10, 3.5.11, 3.5.13, 3.6-т заасан чиг үүрэг болон дүрмийн 1 дүгээр хавсралтын үйл ажиллагааны хүрээ 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.23-т зааснаас бусад барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, сургалт зохион байгуулах, эрхлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.

Дөрөв.Гэрээний хариуцлага

4.1. гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад бусад этгээдэд хохирол учруулсан бол өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцан барагдуулна.

4.2. Дараах нөхцөлийн аль нэг нь бий болсон тохиолдолд яамны санаачилгаар гэрээг цуцалж, учирсан хохирлыг үл маргах журмаар..... бүрэн хариуцна:

4.2.1. гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, байгалийн гамшиг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлаас бусад шалтгаанаар төлөвлөгөөт сургалтыг зохион байгуулаагүй;

4.2.2. сургалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу бус, түүнчлэн холбогдох бусад шаардлагыг зөрчиж зохион байгуулсан, эсхүл сургалтыг зохион байгуулах хүний нөөц, санхүүгийн чадамжгүй нь болох БХБЯ-ны хяналт шинжилгээний газраас хийсэн шалгалтаар тогтоогдсон;

4.2.3. сургалтын үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл үүсгэсэн нь үйл ажиллагаанаас хамааралтай бол;

4.2.4. энэхүү гэрээг байгуулах үед зөвлөх инженерийн хугацаагүй эрхтэй, зөвлөх болон мэргэшсэн инженер, тэргүүлэх болон мэргэшсэн төсөвчдийг аттестатчилах, хуульд зааснаас бусад үндэслэлээр мэргэшлийн зэргийг цуцалсан бол;

4.2.5.Түншлэлийн гишүүдийнбуюу хувь нь түншлэлээс гарахаа илэрхийлж, албан бичгээр мэдэгдсэн бол;

4.2.6. энэхүү гэрээний 2.2-т заасны дагуу гэрээний үүргийн хэрэгжилт 70-аас доош хувиар үнэлэгдсэн тохиолдолд;

4.2.7. хуульд тусгайлан заасан бусад нөхцөл.

4.3. Гэрээтэй холбоотой асуудлаа маргаан үүссэн тохиолдолд хууль тогтоомжийн хүрээнд харилцан тохиролцон шийдвэрлэнэ. Ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Тав.Бусад зүйл

5.1. Гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

5.2. Гэрээний хугацаа дуусахтай зэрэгцэн гэрээг цуцлах санал гараагүй нөхцөлд талууд энэ гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гэрээний хугацааг сунгах, шинээр гэрээ байгуулах хүртэл хэвээр хэрэгжүүлнэ.

5.3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах бол талууд саналаа бичгээр гаргана. Энэ гэрээний 1.2-т заасан хугацааг сунгах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд саналаа нөгөө талд 14-өөс доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

5.4. Энэхүү гэрээг 3 хувь үйлдэх бөгөөд яам 2, 1 хувийг тус тус хадгална.

5.5. Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон, Барилга, хот байгуулалтын сайдын тушаал, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр гэрээ байгуулах үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөн нөхцөлд гэрээг дуусгавар болсонд тооцно.

5.6.Гэрээтэй холбоотой асуудлаар маргаан үүссэн тохиолдолд хууль тогтоомжийн хүрээнд харилцан тохиролцон шийдвэрлэнэ. Ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Гэрээ байгуулсан:

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМНЫ ТӨЛӨӨЛЖ:

Төрийн нарийн бичгийн даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

.....Ц.БАЯРБАТ

Төрийн захиргааны удирдлагын
газрын даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

.....,

Хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот 15170,
Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Барилгачдын талбай-3, Засгийн газрын XII
байр

E-mail: info@mcud.gov.mn

Web: www.mcud.gov.mn

ТҮНШЛЭЛИЙГ ТӨЛӨӨЛЖ:

.....-ын ерөнхийлөгч

.....

“.....”-ын гүйцэтгэх захирал

..... ,

Хаяг:

БАТЛАВ.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.БАЯРБАТ

**БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛТНЫ ДАВТАН СУРГАЛТ, МЭРГЭЖИЛ
ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ, СУНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЧИГ ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭХ ТӨРИЙН БУС, МЭРГЭЖЛИЙН
БАЙГУУЛЛАГЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТЫН
АЖЛЫН ДААЛГАВАР**

2023 оны 12 дүгээр
сарын 21-ний өдөр


Дугаар 2.023/14


Улаанбаатар хот

1	Үндэслэл	Барилгын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д "Төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас энэ хуулийн ...44.7-д заасны дагуу шилжүүлсэн чиг үүргийг төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр шилжүүлэн гүйцэтгүүлж болно" гэж, 44 дүгээр зүйлийн 44.7 дахь хэсэгт "Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох асуудлыг гэрээний үндсэн дээр төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.", Иргэний хуулийн 421.1 дэх хэсэгт "Ямар нэгэн ажлыг гүйцэтгэх тодорхой болзлыг хангаж шалгарсан этгээдэд шагнал буюу эрх олгохоор нийтэд зарласан иргэн, хуулийн этгээд нь зарласан болзол ёсоор шалгарсан этгээдэд тухайн шагнал буюу эрхийг олгох үүрэг хүлээнэ." гэж тус тус заасан.
2	Гүйцэтгэх үүрэг	Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэжлийн зэрэг олгох дүрэм" /Цаашид "Дүрэм" гэх/-ийн 3.5.6, 3.5.7, 3.5.10, 3.5.11, 3.5.13, 3.6-т заасан сургалт зохион байгуулагчийн чиг үүрэг болон дүрмийн 1 дүгээр хавсралтын үйл ажиллагааны хүрээ 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.23-т зааснаас бусад барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, сургалт зохион байгуулах, дүрмийн 3.6-д заасан сургалт эрхлэгчийн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.
3	Үр дүн	Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэжлийн зэрэг олгох дүрэм" /Цаашид "Дүрэм" гэх/-ийн 1 дүгээр хавсралтын 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.23-т зааснаас бусад барилгын салбарын ажилтнуудыг мэргэшүүлэх, давтан сургах сургалтын орчинг олон улсын

		түвшинд хүргэхэд оршино. хөтөлбөрөөр сургах барилгын салбарын ажилтнуудыг бүрдүүлэх.
4	Хэрэгжүүлэх хугацаа	Гэрээний дагуу 1 жил
5	Тавигдах шаардлага	<p><u>5.1.Хүний нөөцийн чиглэлээр:</u></p> <p>5.1.1.Сургалт зохион байгуулагч нь чиг үүргийн хүрээнд: а.сургалтын менежерийг оролцуулсан 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй, орон тооны сургалтын албатай байх; а.1.Сургалтын менежер нь салбарын чиглэлийн мэргэжилтэй, магистр, эсхүл докторын зэрэгтэй, мэргэшлийн аль нэг зэрэгтэй, боловсрол, сургалтын чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх.</p> <p>5.1.2.Сургалт эрхлэгч чиг үүргийн хүрээнд: а/ Дүрмийн 1 дүгээр хавсралтын 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.23-т зааснаас бусад Барилгын салбарын мэргэжилтний үйл ажиллагааны хүрээ (зураг төслийн хүрээний 1.5-1.22, барилга байгууламжийн угсралт, засварын ажлын хүрээний 2.1-2.11, ашиглалтын хүрээний 3.1-3.6, барилгын материал үйлдвэрлэлийн технологийн хүрээний 4.1-4.7, барилгын үйлдвэрлэлийн машин, төхөөрөмжийн хүрээний 5.1-5.3, Төсвийн хүрээний 6.1-6.6) тус бүрээр боловсролын доктор, магистрийн зэрэгтэй, мэргэшлийн зөвлөх зэрэгтэй архитектор, инженер, тэргүүлэх зэрэгтэй төсөвчдөөс бүрдсэн багш нарын бүрэлдэхүүнтэй байх.</p> <p><u>5.2.Үйл ажиллагаа, зохион байгуулалтын чиглэлээр:</u></p> <p>5.2.1.барилгын салбарын төрийн бус, мэргэжлийн байгууллага нь сүүлийн 2 ба түүнээс дээш жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан туршлагатай байх;</p> <p>5.2.2.салбарын мэргэжлийн сургалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулсан туршлагатай байх;</p> <p>5.2.3.байгууллагын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөтэй ажилладаг байх;</p> <p>5.2.4.түншлэлийн гишүүн сургалт эрхлэгч сургалтад ашиглаж байгаа барилгын салбарын шинжлэх ухаан, техник, технологийн болон сургалтын мэргэжлийн гарын авлага, ном товхимол, бүтээлээс бүрдсэн материаллаг баазтай байх;</p> <p>5.2.5. салбарын хууль тогтоомж, дүрэм, журам, норм, дүрмийн сантай байх;</p> <p>5.2.6.үйл ажиллагаа явуулах өөрийн, эсхүл түрээсийн байртай байх;</p> <p>5.2.7. сургалт зохион байгуулах болон сургалт эрхлэх үйл ажиллагааг хэвийн явуулахад ашиглах тоног төхөөрөмж, техник хэрэгсэлтэй байх.</p>

6	Түншлэл	<p>6.1. Барилгын салбарын сургалт эрхлэгч төрийн бус, мэргэжлийн байгууллагууд нь Иргэний хуулийн 476 дугаар зүйлийн 476.3-т заасан шаардлагыг хангасан хамтран ажиллах гэрээ байгуулан түншлэлээр оролцоно.</p> <p>6.2. Түншлэлийн гишүүд өөр бусад барилгын салбарын төрийн бус мэргэжлийн байгууллагатай түншлэн уг уралдаант шалгаруулалтад оролцохыг хориглоно.</p>
7	Бүрдүүлэх материал	<p>7.1.Энэ даалгаврын 5.1-д заасан шаардлагын хангасан болохыг нотолсон хүний нөөцийн баримт бичиг болох боловсролын зэргийн диплом, мэргэшлийн зэргийн гэрчилгээ, нийгмийн даатгалын лавлагааг ирүүлсэн байх;</p> <p>7.2.Төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулсан шийдвэр, улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, төрийн бус, мэргэжлийн байгууллагын бүтэц орон тоог баталсан шийдвэрийн хуулбар;</p> <p>7.3.Төрийн бус, мэргэжлийн байгууллагын дэлгэрэнгүй танилцуулга;</p> <p>7.4.Төрийн бус байгууллагын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу сүүлийн 2 жилийн хугацаанд төрийн эрх бүхий байгууллагад гаргасан үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;</p> <p>7.5.Байгууллагын баталсан үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний хуулбар;</p> <p>7.6.Түншлэлийн гишүүн сургалт эрхлэгчийн сургалтад ашиглаж байгаа барилгын салбарын шинжлэх ухаан, техник, технологийн болон сургалтын мэргэжлийн ном товхимол, бүтээлийн жагсаалт;</p> <p>7.7. Сургалт, үйл ажиллагаандаа ашиглаж буй салбарын хууль тогтоомж, дүрэм, журам, норм, дүрмийн жагсаалт;</p> <p>7.8.Үйл ажиллагаа явуулдаг ажлын байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл Үл хөдлөх эд хөрөнгө хөлслөх /түрээслэх/ гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;</p> <p>7.9.Түншлэлээр оролцож байгаа тохиолдолд түншлэгч нь энэ даалгаврын 6.2-т заасан Хамтран ажиллах гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;</p> <p>7.10.Сургалт, үйл ажиллагаандаа ашиглаж буй тоног төхөөрөмж, техник хэрэгслийн жагсаалт.</p>

Хянасан. Төрийн захиргааны удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч  Ц.Гансүх

Боловсруулсан: ТЗУГ-ын ахлах шинжээч  А.Лхамсэржид

Хуулийн хэлтсийн шинжээч  Г.Гантөр
2023.12.01

